



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/54

Хужирт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумаас буцсан иргэнээс Ковид-19 цар тахлын сэжигтэй тохиолдол илсэрсэнтэй холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 06.00 цагаас тодорхойгүй хугацаагаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумаас орох, гарах болон сум доторх хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хязгаарласугай.

3. Сэжигтэй тохиолдлын ойрын болон дам хавьтал, явсан маршрутыг тогтоон шинжилгээнд хамруулах ажлыг түргэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга хурандаа (Х.Түмэнбаяр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв), Эрэн хайх, аврах бүлгийн бүлгийн дарга, ажиллагааны зааварчлагч (Д.Баянсан) нарт үүрэг болгосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Эрүүл мэндийн төв, “Цэгц тунжин” эмийн сан, эрчим хүч, уст цэгийн үйл ажиллагаанаас бусад төрийн багууллага болон аж ахуйн нэгж, амралт сувилалуудын үйл ажиллагааг түр зогсоосугай.

5. Сумаас орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих хяналтын 6 пост, Шуурхай штабын 24 цагийн жижүүр, сум доторх хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг гарган 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 06.00 цагаас эхлэн хуваарийн дагуу ажиллуулсугай.

6. Уст цэгийн ажиллах цагийн хуваарийг 10.00-17.00 цаг хүртэл ажиллуулсугай.

250100107